



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэшлээрээ бие даан мэргэшлийн санал, дүгнэлт гаргасан , тайлан бичсэн байх / гаргасан санал, дүгнэлтийн тайлангийн эх хувь, он сар өдөр, гарын үсэг, тамга тэмдэгтэй байх, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн бол албан тоотын хувь /;
2. Тухайн мэргэшлээрээ бие даан сургалт зохион байгуулсан байх /түүнийг баталгаажуулах баримт бол батлагдсан сургалтын удирдамж, хөтөлбөр, сургалтын үйл ажиллагааны тайлангийн эх хувь, оролцогчдын зураг/;
3. Эрдэм шинжилгээний судлагааны ажил хийсэн, үнэлгээ хийсэн, өгүүлэл бичсэн, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан бол жагсаалтыг гаргасан байх /түүнийг баталгаажуулах баримт бол эх хувийг хавсаргах, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн, сэтгүүлд илтгэл, өгүүллэг, тойм хэвлүүлсэн 2 ба түүнээс дээш байж болно/;
4. Тухайн горилох мэргэшлийн дагуу мэргэшлийн сургалт, семинарт хамрагдсан жагсаалт гаргах / сургалтын сертификатын эх хувь, олон улсын сургалт, ажлын байрны сургалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт байх ба сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн бүх хэлбэрийн мэргэжлийн сургалт/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэшлээрээ бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргасан, тайлан бичсэн, тушаал, журам, заавар, үндэсний хөтөлбөр боловсруулсан байх /гаргасан санал, дүгнэлтийн тайлангийн эх хувьд он сар өдөр, гарын үсэг, тамга тэмдэгтэй байх ба аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, холбогдох байгууллагад хүргүүлж байсан албан тоотын хувь/;
2. Тухайн мэргэшлээрээ бие даан сургалт зохион байгуулсан байх /батлагдсан сургалтын удирдамж, хөтөлбөр, сургалтын үйл ажиллагааны тайлангийн эх хувь, оролцогчдын зураг/;
3. Эрдэм шинжилгээний судлагааны ажил хийсэн, үнэлгээ хийсэн, өгүүлэл бичсэн, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан бол

жагсаалтыг гаргасан байх /эх хувийг хавсарга, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн, сэтгүүлд илтгэл, өгүүллэг, тойм хэвлүүлсэн 5 ба түүнээс дээш байж болно/;

4. Тухайн горилох мэргэшлийн дагуу сургалт, семинарт хамрагдсан жагсаалт гаргах /сургалтын сертификатын эх хувь, олон улсын сургалт, ажлын байрны сургалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт байх ба сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн бүх хэлбэрийн мэргэжлийн сургалт/;
5. Хоёроос доошгүй мэргэшигчийг дагалдуулан сургаж мэргэжил эзэмшүүлсэн байх /мэргэшигчийн овог нэр, ямар мэргэжлээр, хэзээ, хаана ямар тушаалаар сурсан баталгаажсан эх хувийг хавсаргах/;
6. Шинэ арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх /Зохиогчийн эрхийн гэрчилгээ байж болно/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн мэргэшлээрээ бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргасан, тайлан бичсэн, тушаал, журам, заавар, үндэсний хөтөлбөр, стартеги, хуулийн төсөл боловсруулсан байх /гаргасан санал, дүгнэлтийн тайлангийн эх хувь, он сар өдөр, гарын үсэг, тамга тэмдэгтэй байх ба аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн бол албан тоотын хувь/;
2. Тухайн мэргэшлээрээ бие даан сургалт зохион байгуулсан байх /батлагдсан сургалтын удирдамж, хөтөлбөр, тайлангийн эх хувь, оролцогчдын зураг/;
3. Эрдэм шинжилгээний судлагааны ажил хийсэн, үнэлгээ хийсэн, өгүүлэл бичсэн, бүтээл, ном, гарын авлага, зөвлөмж, санамж боловсруулсан бол жагсаалтыг гаргасан байх /эх хувийг хавсаргах, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн, сэтгүүлд илтгэл, өгүүллэг, тойм хэвлүүлсэн 8 ба түүнээс дээш байж болно/;
4. Тухайн горилох мэргэшлийн дагуу сургалт, семинарт хамрагдсан жагсаалт гаргах /түүнийг нотлох баримт бол сургалтын сертификатын эх хувь, олон улсын сургалт, ажлын байрны сургалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт байх ба сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн бүх хэлбэрийн мэргэжлийн сургалт багтана/;
5. Таваас доошгүй мэргэшигчийг дагалдуулан сургаж мэргэжил эзэмшүүлсэн байх /түүнийг нотлох баримт бол мэргэшигчийн овог нэр, ямар мэргэжлээр, хэзээ, хаана ямар тушаалаар сурсан баталгаажсан эх хувийг хавсаргах/;
6. Шинэ арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх /Зохиогчийн эрхийн гэрчилгээ байж болно/.